



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 72

Арвайхээр

Арвайхээр тохижилт үйлчилгээ Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Арвайхээр тохижилт үйлчилгээ” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм”-ийн 6.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Арвайхээр тохижилт үйлчилгээ Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Удирдах зөвлөлийн дарга: Б.Ууганбаяр (сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

Гишүүд: О.Түвшинтөгс (сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)
Ж.Ганзориг (сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга)
Л.Цэвэлмаа (аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

А.Батдулам (хотын Захирагчийн албаны үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн)

2. Арвайхээр тохижилт үйлчилгээ Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дагаж мөрдөх журам, жилийн ажлын төлөвлөлт, норм, нормативыг тогтоох эдийн засгийн бодит тооцоо судалгаа хийх, үр ашгийг дээшлүүлж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлж, төсвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр тогтмол хангаж ажиллахыг Удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

3. Арвайхээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Арвайхээр тохижилт үйлчилгээ Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Удирдах зөвлөл байгуулах тухай” 2021 оны 10 дугаар тогтоолыг 2021 оны 12 сарын 28-наас хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Ц.ДОНЬДДОРЖ



d/2021/albanbichig/ITHTTogtool/

16732177